

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2014 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 04 дүгээр
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн С.Дэмбэрэл**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтийг Засгийн газраас 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Төрийн байгуулалтын байнгын хороо 2015 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаараа үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, саналын томъёоллыг Эдийн засгийн байнгын хороонд хүргүүлж байна.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, А.Бакей, Н.Батцэрэг, С.Баярцогт, Су.Батболд, Л.Цог, Н.Энхболд нар эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах арга зүй, төлөвлөлт, хэрэгжилтийг дүгнэх хэлбэр, шалгуур үзүүлэлт, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэх хугацаа, дэгийг боловсронгуй болгох; үндсэн чиглэл Засгийн газрын мөрийн хөтөлбөр, төсвийн төлөвлөлт хоорондын уялдааг сайжруулах; жил бүр үндсэн чиглэлийг батлан гаргаж, түүний биелэлтийг ёс төдий хэлэлцэх шаардлагатай эсэхийг судлах зэрэг саналуудыг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, А.Бакей, Н.Батцэрэг, С.Баярцогт, Л.Цог, Н.Энхболд нарын гаргасан Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, батлах, хэрэгжилтийг үнэлэх, дүгнэх, одоогийн практик үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах саналын төслийг 2015 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан бэлтгэж танилцуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороонд даалгасан заалтыг Үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөлд тусгуулах саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл"-ийн биелэлтийн талаар тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**

А.БАКЕЙ